Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45.4 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая.төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2.4 | 21.0 | 18.6 |
| Авлага | 29.8 | 4.8 | (25.0) |
| Бараа материал | 23.9 | 18.2 | (5.7) |
| Үндсэн хөрөнгө | 316.7 | 374.2 | 57.5 |
| **Нийт хөрөнгө** | **372.8** | **418.2** | **45.4** |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр | 5.9 | 11.0 | 5.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 366.9 | 407.2 | 40.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **372.8** | **418.2** | **45.4** |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг болсны дагуу Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаар тоот албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 21.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 18.6 сая төгрөгөөр өссөн байна.
- ✓ Өмнөх онд Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 28.1 сая төгрөг байсныг тайлант онд санхүүжилтээр авч барагдуулж оны эцэст 4.8 сая төгрөгийн авлага нь байгууллага, ажиллагсдаас авах цалингийн урьдчилгааны авлага байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 5.7 сая төгрөгөөр буурсан нь 2.4 сая төгрөгийн нүүрсийг дотоод журамд заасны дагуу эмч ажилчдад олгосон, 3.9 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг зарцуулсан холбоотой буурсан байна.
- ✓ Өр төлбөр оны эхэнд 5.9 сая төгрөгийг барагдуулан тайлант онд Вивазоне, Бүрэн стандарт ХХК-тай дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулан оны эцэст 10.9 сая, бусад тооцооны 0.1 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.
- ✓ Засгийн газрын хувь оролцоо дансны хувьд тайлант онд 30.9 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас өссөн үзүүлэлттэй байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 405.9, орон нутгийн төсвөөс 14.1, эрүүл мэндийн даатгалын сангаас 35.7 сая төгрөг бүгд 455.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж тайлант оны эхэнд 461.1 сая төгрөгөөр баталж, оны эцэст 509.8 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 524.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 24.8 сая төгрөг, ЭМГ-аас 0.3 сая төгрөг нийт 549.6 сая төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвөөс 24.8 сая төгрөгийн санхүүжилт, ЭМДС-аас өмнөх оны 28.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч 531.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая. төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | | |
| 1 | 71602/80302- Нэг иргэнд ногдох нормативаар | 305.5 | 326.4 | (20.9) | 106.8 |
| 2 | 71602/81603- Үндсэн мэргэжлийн тусламж | 129.4 | 129.7 | (0.3) | 100.2 |
| 3 | 71602/83603- Нэмэлт- дээд шатны төсвөөс хуваарилсан | 50.1 | 50.1 | - | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 71602/80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 15.2 | 15.2 | | 100 |
| 5 | 71602/80112- Нийтлэг үйлчилгээ | 4.9 | 4.9 | | 100 |
| 6 | 71602/8030 - Урьд оны өр | 4.7 | 4.7 | | 100 |
| ДҮН | | 509.8 | 531.0 | -21.2 | 104.2 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны санхүүжилтийн авлага 25.9 сая төгрөгийг ЭМДС-аас авч улсын төсвийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан тул нэмэлт санхүүжилтийн тайлан тусгайлан гаргаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2023 оны 02 дугаар сарын 28-наас 03 дугаар сарын 03–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07 албан бичгээр ирүүлсэн, аудиторт шаардлагатай баримт материалыг 2023 оны 02 дугаар сарын 24-нд хүлээлгэн өгсөн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 590.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоогоогүй болно.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Ховд аймгийн Ховд сумын ЭМТөв нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд албан томилолт, 10 дугаар зүйлд цалин хөлс, нэмэгдэл, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу тайлант онд орлогын 23 ажил гүйлгээ, зарлагын 1 ажил гүйлгээг мэдээлээгүй, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр оруулаагүй, тайлант хугацаанд 147 мэдээллийг хугацаанд нь оруулсан, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 587.8 сая төгрөгийн 1.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.1 сая төгрөгийн албан шаардлага, 585.3 сая төгрөгийн 3 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 33.3 хувьтай байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1.4 | 1 | 1.4 | 100 |
| Албан шаардлага | 2 | 1.1 | - | - | - |
| Зөвлөмж | 3 | 585.3 | | | - |
| **Нийт дүн** | **6** | **587.8** | **1** | **1.4** | 33.3 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмч мэргэжилтэнд олгосон илүү цагийн нэмэгдэл, эм болон шатахууны зарцуулалтыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 49.7 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг 1.4 сая төгрөгөөр илүү бүртгэсэн,
- Өглөг 10.9 сая төгрөгөөр  дутуу тусгасан,
- Аймгийн ИТХ-ын 7/15 тоот тогтоолоор 49-99 хоа улсын дугаартай 28.0 сая төгрөгийн үнэ бүхий пургон автомашиныг Шим ус ОНӨААТҮГ-т шилжүүлснийг данс бүртгэлээс хасаагүй,
- Тайлант үеийн үр дүнг 9.4 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 117.3 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс 6.6 сая төгрөгийн төлбөрийн акт, хариуцлага тооцуулах албан шаардлага, 110.7 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1** Байгууллагын хэрэгцээнд шаардлагагүй гоо сайхны 0.3 сая төгрөгийн материал худалдан авсан, нийгмийн даатгалын шимтгэлийн 2.4 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, цалингийн урьдчилгааг ТАЦНС-ээр дамжуулаагүй Төрийн сангаар хянуулан 3.9 сая төгрөг нийт 6.6 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй", Засгийн газрын 163 дугаар тогтоол 1-д "Төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж, төрийн албан хаагчийн орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн албаны хүний нөөцийн мэдээлэлд суурилсан төрийн албаны цалингийн нэгдсэн системийг 2020 оны 5 дугаар сараас бүх шатны төсвийн байгууллагад үе шаттайгаар нэвтрүүлэх" гэсэн заалтыг мөрдөөгүй,  "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.2 Албан шаардлага / хариуцлага тооцуулах/

**5.2.1** Төсвийн шууд захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт,  2022 оны батлагдсан төсөв, хагас жилийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр дараа жилийн төсвийн төсөл, тайлант онд 5 сая төгрөгөөр дээш орлогын 23 ажил гүйлгээ, зарлагын 1 ажил гүйлгээг  Шилэн дансны дансны хуульд заасан мэдээллийг байршуулаагүй өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.1-д "Төсвийн ерөнхий захирагч

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ” 3.1.3-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 1.20 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар”, 3.1.9-д “хагас жилийн санхүүгийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор”, 3.1.10-д “ санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор PDF форматаар;”, 3.1.11-д “аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар;”, 3.1.16-д “ дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар” гэсэн заалтуудтай нийцээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж**

### 5.3.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* ЭМТ-ийн эмч мэргэжилтэнд 2 дугаар улирлын мөнгөн урамшуулал олгох тушаал шийдвэр нь он, сар,өдөргүй, дугааргүй, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй бичиг хэрэг, цайны материал худалдан авсан, хэчнээн хүн хамрагдсан нь тодорхой бус, нотлох анхан шатны баримтгүй, эмч ажилчдад 15 тонн нүүрс олгохдоо тушаал шийдвэргүйгээр 14.5 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар "Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ гаргахгүй байх, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр арга хэмжээний зардлыг үр дүнтэй зарцуулах

### 5.3.2 Бараа материалын тайлан гаргалттай холбоотой

*Илрүүлэлт* Тайлант онд 85.2 сая төгрөгийн эм, шатахуун худалдан авсан, эмийн болон шатахууны тайлан гаргалт хангалтгүй , жолоочийн тооцоог сар бүр бодоогүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.Сангийн сайдын 2017 оны 347 дугээр тушаалын НХМаягт БМ-9-д “бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна”, НХМаягт ТМ-4-д Жолоочийн тооцооны хуудас, Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа материалын тайланг сар бүр гаргах, жолоочийн тооцоог бодож хэвших

### 5.3.3 Тогтмол зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Орон нутгийн төсвөөс тогтмол зардлыг санхүүжүүлэх батлагдсан төсвөөс байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны шатахуун, хоол хүнс, урсгал засварын материал худалдан авахад 6.6 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж :* Төсвийг бодитой төлөвлөх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, талаар анхааран ажиллах,

### 5.3.4 Цалин хөлс олгохтой холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Нягтлан бодогч, эд хариуцагч нярав нарт ур чадвар, үр дүнгийн урамшуулал, ажил хавсран ажилласны нэмэгдэлд нийт 4.3 сая төгрөгийг зарцуулсан ч санхүү бүртгэлээр тавих хяналт хэрэгжүүлээгүй, эд хариуцагч бараа материалын гаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 1-д "Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж :* Ажлын үр дүнг бодитой дүгнэн үр дүн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг олгож хэвших

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл / сая төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэхээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого илүү хүлээн зөвшөөрч бүртгэсэн | 1 | 1.4 | | | 1 | 1.4 | 1 | 1.4 |
| Өглөг дутуу тусгасан | 1 | 10.9 | 1 | 10.9 | | | 1 | 10.9 |
| Аймгийн ИТХ-ын тогтоолоор тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэх шийдвэрлэсэн данс бүртгэлээс хасаагүй | 1 | 28.0 | 1 | 28.0 | | | 1 | 28.0 |
| Тайлант үеийн үр дүн дутуу илэрхийлсэн | 1 | 9.4 | | | 1 | 9.4 | 1 | 9.4 |
| **Дүн** | **4** | **49.7** | **2** | **38.9** | **2** | **10.8** | **4** | **49.7** |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /сая.төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын хэрэгцээнд шаардлагагүй гоо сайхны 0.3 сая төгрөгийн материал худалдан авсан, нийгмийн даатгалын шимтгэлийн 2.4 сая төгрөгийн авлага бүртгээгүй, ТАЦНС-ээр дамжуулаагүй Төрийн сангаар дамжуулан 5.5 сая төгрөгийн ажил гүйлгээгээр цалингийн урьдчилгаа олгож, суутган төсөвт төвлөрүүлээгүй | 1 | 6.7 | 1 | 6.7 | | | | |
| ЭМТ-ийн эмч мэргэжилтэнд улирлын мөнгөн урамшуулал олгох тушаал шийдвэр нь он, сар,өдөргүй, дугааргүй, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй бичиг хэрэг, цайны материал худалдан авсан, хэчнээн хүн хамрагдсан нь тодорхой бус, нотлох анхан шатны баримтгүй, эмч ажилчдад 15 тонн нүүрс олгохдоо тушаал шийдвэргүйгээр зарцуулсан | 1 | 14.5 | | | | | 1 | 14.5 |
| Нягтлан бодогч, эд хариуцагч нярав нарт ур чадвар, үр дүнгийн урамшуулал, ажил хавсран ажилласны нэмэгдэлд нийт 4.3 сая төгрөгийг зарцуулсан ч санхүү бүртгэлээр тавих хяналт хэрэгжүүлээгүй, эд хариуцагч бараа материалын гаргаагүй | 1 | 4.3 | | | | | 1 | 4.3 |
| Эмийн болон шатахууны тайлан гаргалт хангалтгүй, жолоочийн тооцоог бүрэн р бодоогүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй | 1 | 85.2 | | | | | 1 | 85.2 |
| Орон нутгийн төсвөөс тогтмол зардлыг санхүүжүүлэх батлагдсан төсвөөс байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны шатахуун, хоол хүнс, урсгал засварын материал худалдахад зарцуулсан | 1 | 6.6 | | | | | 1 | 6.6 |
| Дүн | **5** | **117.3** | **1** | **6.7** | **-** | **-** | **4** | **111** |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /сая.төгрөгөөр /

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | |
|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага /хариуцлага тооцуулах/ | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | |
| Төсвийн шууд захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, 2022 оны батлагдсан төсөв, хагас жилийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр дараа жилийн төсвийн төсөл, тайлант онд 5 сая төгрөгөөр дээш орлогын 23 ажил гүйлгээ, зарлагын 1 ажил гүйлгээг Шилэн дансны дансны хуульд заасан мэдээллийг байршуулаагүй өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй | 1 | - | 1 | - |
| Дүн | 1 | | 1 | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**ХОВД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 03 сарын 06 өдөр　　　Дугаар 21/A2160424　　　Ховд

ХОА-2022/163/НА/-СТА-ТШЗ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг илүү төлсөн авлагаар бүртгээгүй, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагагүй гоо сайхны материал худалдан авсан, ТАЦНС-ээр дамжуулалгүй албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүйтэй холбоотой 6668.7 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй", Засгийн газрын 163 дугаар тогтоол 1-д "Төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж, төрийн албан хаагчийн орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн албаны хүний нөөцийн мэдээлэлд суурилсан төрийн албаны цалингийн нэгдсэн системийг 2020 оны 5 дугаар сараас бүх шатны төсвийн байгууллагад үе шаттайгаар нэвтрүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв,санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 6668727 /зургаан сая зургаан зуун жаран найман мянга долоон зуун хорин долоон төгрөг/-ийг төлүүлж Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ховд сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Жемисгүль, нягтлан бодогч Х.Дүйсенбек нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

*ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР* 　　　*Х.БОЛДБААТАР*

*АХЛАХ АУДИТОР* 　　　*Д.НАРАНТУУЛ*

1

[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 06 өдөр Дугаар 12/А2160424 Ховд

ХОА-2022/163/-СТА-ТТ3

## САХИЛГЫН ШИЙТГЭЛ НОГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар төсвийн шууд захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, 2022 оны батлагдсан төсөв, хагас жилийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр оруулаагүй, дараа жилийн төсвийн төсөл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 23 ажил гүйлгээ, зарлагын 1 ажил гүйлгээг Шилэн дансны дансны хуульд заасан мэдээллийг байршуулаагүй өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд *заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг* хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.1-д "Төсвийн ерөнхий захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ" 3.1.3-д "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 1.20 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар", 3.1.9-д "хагас жилийн санхүүгийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор", 3.1.10-д " санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор PDF форматаар;", 3.1.11-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар;", 3.1.16-д " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуульд заасны дагуу холбогдох мэдээллийг Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд бүрэн мэдээлж хэвших



[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

2. Дээрх зөрчилтэй холбоотой Ховд сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Х.Дүйсенбект хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 05-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт[1] хариуг албан бичгээр ирүүлэхийг ирүүлэхийг Ховд сумын Эрүүл мэндийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Жемисгүлд хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

*ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР* Х.БОЛДБААТАР

*АХЛАХ АУДИТОР* Д.НАРАНТУУЛ

[1] Монгол улс, Ховд аймаг,Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас:70433061, 70432545



[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061